



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2013 оны 05 сарын 02 өдөр

Дугаар A/197

Улаанбаатар хот

Аргачлал шинэчлэн батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 4, 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Засгийн газрын 1998 оны 92 дугаар тогтоол, 1994 оны 171 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэм”-ийн 15-ын “а”, 16-ын “к” заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Даатгуулагчийн үндсэн ажил олгогчоос гадна нэг буюу түүнээс дээш байгууллагад ажиллан илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох аргачлал”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Илүү төлсөн шимтгэлийг буцаан олгосон тухай баримт”-ын загварыг хоёрдугаар хавсралтаар, “Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголтын тайлан”-гийн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

Хоёр. Аргачлалын дагуу илүү төлсөн шимтгэл буцаан авах даатгуулагчдын жагсаалтыг гаргаж аймаг /дүүрэг/-ийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэх, програм хангамжид холбогдох өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулахыг Санхүү бүртгэлийн газар /Ч.Чулуунчимэг/, Мэдээллийн технологийн төв /Г.Хүрэлбаатар/-д даалгасугай.

Гурав. Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголтыг энэхүү аргачлалд заасны дагуу зохион байгуулахыг аймаг /дүүрэг/-ийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

Дөрөв. Нийгмийн даатгалын сангийн жил бүрийн төсвийн төсөлд даатгуулагчид буцаан олгох илүү төлсөн шимтгэлийг тусгах арга хэмжээ авахыг Санхүү бүртгэлийн газар /Ч.Чулуунчимэг/-т даалгасугай.

Тав. Аймаг, нийслэлийн хэмжээнд илүү төлсөн шимтгэлийг буцаан олгож буй үйл ажиллагааг холбогдох аргачлалын дагуу хэрэгжүүлж байгаа эсэхэд жил бүр дотоодын хяналт, шалгалт хийх, илүү төлсөн шимтгэл буцаан авах даатгуулагчдын жагсаалттай холбоотой иргэдийн гомдлыг тухай бүр барагдуулж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээний газар /Н.Ариунаа/-т даалгасугай.

Зургаа. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2012 оны А/58 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.


Долоо. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /О.Байгалмаа/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ЦУРТНАСАН

Нийгмийн даатгалын ерөнхий газрын  
даргын 2013 оны 5 дүгээр сарын 02-ны  
өдрийн А/197 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт



## ДААТГУУЛАГЧИЙН ҮНДСЭН АЖИЛ ОЛГОГЧООС ГАДНА НЭГЭЭС ДЭЭШ БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАН ИЛҮҮ ТӨЛСӨН ШИМТГЭЛИЙГ БУЦААН ОЛГОХ АРГАЧЛАЛ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү аргачлалыг тухайн жилд үндсэн ажил олгогчоос гадна нэгээс дээш байгууллагатай хөдөлмөрийн гэрээ болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж шимтгэл төлсөн даатгуулагч хүсвэл илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох, залруулгын гүйлгээ хийж даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд бүртгэсэн дүнг шинэчлэн тооцох, хяналт тавих, тайлан гаргах, хариуцлага тооцохтой холбоотой харилцааг зохицуулахад баримтална.

1.2 Даатгуулагч хүсэлтээ гаргасан тохиолдолд түүний нийгмийн даатгалын санд тухайн жилд илүү төлсөн шимтгэлийг тооцон хуульд заасан хугацаанд буцаан олгоно.

1.3 Нийгмийн даатгалын ерөнхий газар нь даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийн буцаан олгох дүнгээр нийгмийн даатгалын сангуудын шимтгэлийн орлогыг төсвийн төслийн болон төсөөллийн жилүүдэд бууруулан төлөвлөх, нийгмийн даатгалын сангийн бүртгэл тооцоо, програм хангамжид өөрчлөлт оруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

### Хоёр. Даатгуулагчийн илүү төлсөн шимтгэл буцаан авах эрх, түүнийг тооцох

2.1 Тухайн сард үндсэн ажил олгогчоос гадна нэгээс дээш байгууллагад ажилласан даатгуулагчийн цалин хөлс, орлогын нийлбэр дүн нь Засгийн газрын тогтоосон тухайн үед мөрдөж буй шимтгэл ногдуулах сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээнээс хэтэрч, уг хэтэрсэн хэмжээнээс шимтгэл төлсөн бол илүү төлсөн шимтгэлээ хүсэлт гарган буцаан авч болно.

2.2 Мэдээллийн технологийн төв даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, өгөгдлийн сангийн мэдээлэлд тулгуурлан дараа оны эхний улиралд багтаан илүү төлсөн шимтгэл авах эрх бүхий даатгуулагчийн жагсаалтыг гаргаж Санхүү бүртгэлийн газарт хүргүүлнэ



2.3 Мэдээллийн технологийн төвөөс гаргасан жагсаалтад дурдсан даатгуулагчийн мэдээллийг Санхүү бүртгэлийн газар хянаж, хэвлэн, хуудас бүрт тэмдэг дарж баталгаажуулан албан тоотын хамт Хяналт шинжилгээ, үнэлгээний газар болон аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлнэ.

2.4 Илүү төлсөн шимтгэл буцаан авах даатгуулагчийн жагсаалттай холбоотой иргэдийн гомдлыг Хяналт шинжилгээ, үнэлгээний газар тухай бүр барагдуулж ажиллана.

### Гурав.Илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох

3.1 Илүү төлсөн шимтгэлийг тухайн даатгуулагчийн үндсэн ажил олгогчийн шимтгэлийн тооцоо хийдэг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс тооцоо хийж даатгуулагчид олгоно.

3.2 Хэрэв даатгуулагч илүү төлсөн шимтгэлээ авах үедээ ажилгүй болсон бол үндсэн ажил олгогчийн шимтгэл төлж байсан аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс тооцоо хийж даатгуулагчид олгоно.

3.3 Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийг даатгуулагч өөрийн биеэр ирж хүсэлт гаргасан тохиолдолд, баталгаажсан нийгмийн даатгалын дэвтэр, үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогоос төлсөн шимтгэлийг бүртгэх хуудас, хүчин төгөлдөр иргэний үнэмлэх, банкны харилцах, хадгаламж, картын дансны (аль нэг) дугаарыг тус тус үндэслэн олгоно.

3.4 Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн шимтгэл илүү төлсөн даатгуулагчийн жагсаалтыг өөрийн мэдээллийн сан болон энэ журмын 3.3-т дурдсан баримт, бичигтэй тулган шалгасны үндсэн дээр илүү төлсөн шимтгэлийг тухайн даатгуулагчийн хүсэлтийн дагуу түүний нэр дээр нээсэн банкны харилцах, хадгаламжийн эсвэл картын дансанд энэ журмын 2.2-т заасан жагсаалтыг хүргүүлсний дараа сарын 30 хоногийн дотор нэг удаа бэлэн бусаар шилжүүлнэ.

3.5 Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь даатгуулагчид илүү төлсөн шимтгэлийг буцаан олгосонтой холбогдуулан тухайн даатгуулагчийн ажил олгогчоос ирүүлсэн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн даатгалын гэрчилгээнд ямар нэг өөрчлөлт хийхгүй бөгөөд харин мэдээллийн баазад даатгуулагчийн илүү шимтгэл төлсөн тухайн сарын дүнгээс бууруулан бүртгэнэ.

Жишээ нь:

Инженер “Г” нь барилгын компанид хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг, сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь 900 000 төгрөг, 2011 оны 5 сард “А” компанид гэрээгээр давхар ажиллан 720 000 мянган төгрөгийн, 8 сард “Б” компанид гэрээгээр ажиллан 630 000 мянган төгрөгийн цалин авч шимтгэл төлсөн гэвэл тухайн даатгуулагчийн:

- 5 сард төлсөн шимтгэлээс 90 000 ₮)	<u>21 600 төгрөг,</u>	(900 000 * 10 % =
	<b>хасаж</b>	<u>(720 000 * 10 % =</u>
<u>72 000 ₮)</u>		1 620 000 *10 % =
<b>162 000 ₮ нийт төлсөн</b>		
<u>1 404 000 *10 % = 140 400 ₮</u>	<b>төлөх ёстой</b>	
		<b>зөрүү 216 000 *10 %</b>
<b>= 21 600 ₮</b>		

- 8 сард төлсөн шимтгэлээс 90 000 ₮)	<u>12 600 төгрөг,</u>	(900 000 * 10 % =
	<b>хасаж</b>	<u>(630 000 * 10 % =</u>
<u>63 000 ₮)</u>		1 530 000 *10 % =
<b>153 000 ₮ нийт төлсөн</b>		
<u>1 404 000 *10 % = 140 400 ₮</u>	<b>төлөх ёстой</b>	
		<b>зөрүү 126 000 * 10 %</b>
<b>= 12 600 ₮</b>		

-Нийт 34 200 төгрөгийн илүү төлсөн шимтгэлийг буцаан олгоно.

3.6 Илүү төлсөн шимтгэлийг даатгуулагчид олгохдоо “Илүү төлсөн шимтгэлийг буцаан олгосон тухай баримт”-ыг (хавсралт 2) үнэн зөв бөглөж, гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулан нэг хувийг даатгуулагчид, үлдэх хувийг харилцах дансны баримтанд хавсаргана. Мөн баталгаажсан нийгмийн даатгалын дэвтэр, үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогоос төлсөн шимтгэлийг бүртгэх хуудсын зурагтай хэсэг, илүү шимтгэл төлсөн он, сартай нүүрийн хэсэг, хүчин төгөлдөр иргэний үнэмлэх, банкны харилцах, хадгаламж, картын хуулбарыг дансны харилцах дансны баримтанд хавсаргана.

3.7 Мэдээллийн технологийн төв даатгуулагчийн нэрийн данс дахь мэдээлэлд энэ журмын 3.6-д заасантай ижил мэдээлэл бүхий цэс нээж илүү төлсөн шимтгэлийн мэдээллийг оруулах, харах, судалгаа авах боломжийг Санхүү бүртгэлийн газарт, хянах боломжийг Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт олгож ажиллана.

3.8 Мэдээллийн технологийн төв буцаан олгосон шимтгэлийн дүнгээр даатгуулагчийн нэрийн дансны тухайн жилийн орлогыг бууруулан тооцно.

Дөрөв. Илүү төлсөн шимтгэл буцаан олгосон залруулгын бүртгэл

4.1 Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь илүү төлсөн шимтгэлийг даатгуулагчид олгохдоо дараах залруулгын гүйлгээ хийнэ. Үүнд:

<u>Дебит</u>	4101 Тэтгэврийн даатгалын сан	
70 хувиар		
	4102 Тэтгэмжийн даатгалын сан	8 хувиар
	4104 Эрүүл мэндийн даатгалын сан	20 хувиар
	4105 Ажилгүйдлийн даатгалын сан	2 хувиар

Кредит Илүү төлсөн шимтгэлийн өглөг /**шинэ данс нээх**/ 100 хувиар

Жишээ:

Багш "Б" Монгол бизнес дээд сургууль хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг, үндсэн ажлын сарын цалин 650 000 төгрөг, 2012 оны 10 сард хоёр хувийн сургуульд тус бүр 500 000 төгрөгийн цалинтай ажил гэрээгээр хийж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн гэвэл:

Нийт илүү төлсөн шимтгэл: 24 600 ₮ (**1 650 000 -1404 000 = 246 000 \*10%**)

<u>Дебит</u>	4101 Тэтгэврийн даатгалын сан	70 хувиар
(17 220₮)		
	4102 Тэтгэмжийн даатгалын сан	8 хувиар ( 1 968₮)
	4104 Эрүүл мэндийн даатгалын сан	20 хувиар ( 4 920₮)
	4105 Ажилгүйдлийн даатгалын сан	2 хувиар ( 492₮)

Кредит Илүү төлсөн шимтгэлийн өглөг /**шинэ данс нээх**/ 100 хувиар (24 600₮)



4.2 Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь илүү төлсөн шимтгэлийг даатгуулагчид бэлэн бусаар олгохдоо дараах гүйлгээ хийнэ. Үүнд:

<u>Дебит</u>	Илүү төлсөн шимтгэлийн өглөг / <i>шинэ данс нээх</i> /	100
хувиар (24 600₮)		
<u>Кредит</u>	Харилцах	
хувиар (17 220₮)	1102 Тэтгэврийн даатгалын сан	70
1 968₮)	1103 Тэтгэмжийн даатгалын сан	8 хувиар (
4 920₮)	1105 Эрүүл мэндийн даатгалын сан	20 хувиар (
( 492₮)	1106 Ажилгүйдлийн даатгалын сан	2 хувиар

4.3 Залруулгын гүйлгээ хийсэн баримтыг харилцах дансны баримтанд хавсаргана.

#### Тав. Бусад


5.1 Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга, санхүү бүртгэлийн албаны дарга, хяналт, мониторингийн албаны дарга, сангийн нягтлан бодогч нь илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт, бүртгэлд хяналт тавина.

5.2. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс “Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголтын тайлан”-г (Хавсралт 3) дараа оны эхний улиралд багтаан Санхүү бүртгэлийн газарт хүргүүлнэ.

5.3 Нийгмийн даатгалын ерөнхий газар нь аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох ажил энэ журмын дагуу хэрэгжиж байгаа эсэхийг шалгаж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.4 Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн шимтгэл илүү төлсөн даатгуулагчийн жагсаалтад ороогүй даатгуулагчид буцаан олголт хийсэн, илүү төлсөн шимтгэлийг даатгуулагчид өөрт нь бус өөр хүнд олгосон, жагсаалтад зааснаас өөр дүнгээр буцаан олголт хийсэн болон бусад зөрчил гаргасан буруутай ажилтнаар илүү төлснөөр тооцож буцаан олгосон төлбөрийг даатгалын санд төлүүлэх бөгөөд нийгмийн даатгалын ажилтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын  
2013 оны 05 сарын 02-ны А/197 дугаар  
тушаалын хоёрдугаар хэсрэлт



“Илүү төлсөн шимтгэлийг буцаан олгосон тухай баримт”

Хэлтсийн нэр: .....  
 Даатгуулагчийн регистрийн дугаар: .....  
 Даатгуулагчийн: Ургийн овог: ..... Эцэг/эхийн нэр: ..... Даатгуулагчийн нэр: .....  
 Он: ..... Сар: .....

Сар	Үндсэн ажил олгогчийн нэр	ажил олгогч 1	ажил олгогч 2	ажил олгогч 3	ажил олгогч 4	ажил олгогч 5	Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэр	Төлсөн шимтгэл	Төлбөл зохих шимтгэл	Буцаан олгосон илүү төлсөн шимтгэл
1	2	3	4	5	6	7	/2+3+4+5+6+7/	8	9	/8-9/
1										
2										
3										
4										
5										
6										
7										
8										
9										
10										
11										
12										
	Дүн									

Хүлээн авсан: ..... Овогтой ..... / ..... /  
 гарын үсэг

Хүлээлгэн өгсөн:  
 Нийгмийн даатгалын байцаагч / ..... /  
 гарын үсэг

Хянасан:  
 Ерөнхий нягтлан бодогч / ..... /  
 гарын үсэг

..... оны ..... сарын .....-ний өдөр



